

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ИНДЕКСИЙН ТООЦООЛОЛ

Б.Энхцэцэг, (Ph.D), Хүн ам зүйн дэд профессор. Хүн Амын Сургалт Судалгааны Төв,
Шинжлэх Ухааны Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Хураангуй

Нийгмийн хамгааллын стратегид нийгмийн хамгаалал гэдэг нь “үр өгөөжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмзэг аюултай байдал болон орлогогүй болохоос сэргийлэх чадварыг бий болгосноор ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглэгдсэн багц бодлого, хөтөлбөр” гэжээ. Энэхүү ажлаар Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцоог товч тайлбарлан харуулж, Азийн хөгжлийн банкнаас боловсруулсан Нийгмийн хамгааллын индекс (НХИ) тооцох аргачлалаар Монгол улсын нийгмийн хамгааллын зардал, үр ашиг, зорилтот бүлэгт хэрхэн чиглэж байгааг тооцон дүгнэлт хийлээ.

2012 оны байдлаар НХИ 0.249 буюу Монгол улсын нийгмийн хамгааллын дундаж зардал ядуурлын шугамын 25 орчим хувьтай тэнцүү байв. Нийгмийн хамгааллын гүнзгийрэлт 0.172 байгаа нь нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдсан нэг хүнд ногдох зардлын хэмжээ ядуурлын шугамын зардлын 17%-тай тэнцэж байна. Нийгмийн хамгааллын индексийн хүрээ 1.466 гарсан нь нийгмийн хамгааллын зардал зорилтот хүн амын 146%-ийг хамарчээ. Ядуу хүн амын хувьд НХИ 0.067 гарсан бол ядуу бус хүн амын хувьд 0.183 байна. Эндээс нийгмийн хамгааллын зардал ядуугаас илүү ядуу бус хүн амд ихээхэн зарцуулагджээ.

Нийгмийн хамгааллын зардал жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч нэг хүнд ногдох зардал, үр ашгийн хэмжээ бага, нийгмийн хамгаалалд хамрагдах ёстой хүн амын хамрагдалтын түвшин бага байгаа нь нийгмийн хамгаалалд зарцуулж буй хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай болохыг судалгаа, тооцоолол нотолж байна.

Түлхүүр үгс: Нийгмийн хамгааллын индекс, Нийгмийн хамгааллын гүнзгийрэлт, Нийгмийн хамгааллын хүрээ

ОРШИЛ

Нийгэмд хичнээн их чадавхи бий болж, боломж үүссэн ч үүнээс гадуур орхигддог хүмүүс байсаар байна. Үүнд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бусад бүлгийн хүмүүс хамаарна. Эдгээр хүмүүс нөхцөл байдлаасаа шалтгаалан бий болсон боломжуудыг ашиглаж чаддаггүй. Тэдэнд амьдрах, сайн сайхан амьдрахын тулд нийгмийн халамж, хамгааллын сүлжээ шаардлагатай. Өргөн хүрээнд авч үзвэл, нийгмийн хамгааллын төлбөр хэр их байх ёстой талаар ихээхэн маргаан явагддаг. Хэрвээ хэмжээ нь хэт өндөр бол хүмүүс ажил хийх сонирхолгүй болж болно. Хэрвээ хэтэрхий нээлттэй бөгөөд бага бол үнэхээр шаардагдаж байгаа хүмүүсийг хамруулахгүй байж болно. Хөгжиж буй орнуудад хоёр дахь тохиолдол нь илүү түгээмэл байдаг. Хамгийн ихээр шаардлагатай байгаа орнуудад нийгмийн халамжийн сүлжээ хамгийн сул байдаг ба ДНБ-ий таван хувиас хэтэрдэггүй.

Нийгэм хөгжихийн хэрээр хүний хэрэгцээ шаардлага нэмэгдэж байдаг бөгөөд энэ

нь нийгмийн хамгааллын хүрээг зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд үзүүлэх туслалцаа төдийгөөр хязгаарлаж болохгүй харин инфляци, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн зүгээс хүний амьдралд нөлөөлж буй сөрөг үзэгдлүүдтэй холбон авч үзэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Энэхүү ажлаар Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцоог товч тайлбарлан харуулж, Азийн хөгжлийн банкнаас боловсруулсан Нийгмийн хамгааллын индекс тооцох аргачлалаар Монгол улсын нийгмийн хамгааллын зардал, үр ашиг, зорилтот бүлэгт хэрхэн чиглэж байгааг тооцон дүгнэлт хийлээ.

Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцооны тухай

Монгол улсын Үндсэн хуулиар иргэн бүр амьд явах эрхтэйг баталгаажуулж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах эрх, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эхчүүдэд олгох тусламж дэмжлэгийг хуулинд тусгасан. Нийгмийн хамгааллын тогтолцоог нийгмийн

даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар зохицуулж, Монгол улсын Их хурлаар Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг тус тус баталжээ.

Нийгмийн даатгал нь иргэн /цаашид “даатгуулагч” гэх/ болон төр аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх тухай арга хэмжээ юм. Иргэд дээр дурдсан тохиолдолд тэтгэвэр тэтгэмж авахын тулд хөдөлмөрийн чадвартай буюу ажил эрхэлж байхдаа нийгмийн даатгалд хуулиар тогтоосон шимтгэл төлж байдаг бөгөөд түүнээс үүссэн хуримтлалаар нийгмийн даатгалын сан бүрэлддэг.

Нийгмийн даатгал нь тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний, ажилгүйдлийн гэсэн таван төрөлтэй. Жишээ нь: Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсны гэсэн 3 төрлийн тэтгэвэр олгоно. Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно. Иргэд заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хоёр хэлбэрийн даатгалын аль нэгэнд хамрагдана. Өмчийн төрөл харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс заавал даатгалд хамрагдах бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй хүмүүс, малчид нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ хийж, сайн дурын даатгалд хамрагдана.

Нийгмийн халамж нь бие даан амьдарч өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, төрийн зүгээс зайлшгүй туслалцаа дэмжлэг үзүүлэх шаардлагатай бөгөөд дагаж мөрдөж буй даатгалын хуулиар тэтгэвэр тэтгэмж авах эрх үүсээгүй нийгмийн эмзэг бүлгийг төр ивээлдээ авч амьдрал ахуйд нь туслах

шаардлагаас урган гардаг юм. Нийгмийн халамжийн арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төр хариуцдаг. Нийгмийн халамж гэж хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эцэг эх болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох тухай агуулга бүхий нийгмийн хамгааллын арга хэмжээг хэлнэ.

Нийгмийн халамж нь:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж
- Нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн хоёр үндсэн төрөлтэй, хуулиар нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн хүрээ, үйлчилгээний арга хэлбэрийг тодорхойлсон байдаг.

Хөдөлмөр эрхлэлтийн бүрэлдэхүүн хэсэг нь ядуурлыг бууруулах, хөдөлмөрийн зохистой нөөцийг бий болгоход чиглэгддэг. Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль батлагдан гарч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулагдсан.

Нийгмийн хамгааллын индекс

Нийгмийн хамгаалал гэж юу вэ? гэсэн тодорхойлолт энэ чиглэлээр ажиллаж буй Дэлхийн банк, Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг хөгжлийн агентлагуудын хувьд ялгаатай хэдий ч ерөнхий зүй тогтол бий. Азийн хөгжлийн банкны 2001 оны Нийгмийн хамгааллын стратегид “...эмзэг бүлгийг эрсдлээс хамгаалах, эрсдлийг бууруулах, эрсдлийг даван туулах” гэж тодорхойлжээ. Иймд ядуу болон ядуу бус **эмзэг бүлгийг** нийгмийн хамгаалалд хамруулах нь чухал гэсэн үг.

Түүнчлэн Нийгмийн хамгааллын стратегид нийгмийн хамгаалал гэдэг нь “үр өгөөжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмзэг аюултай байдал болон орлогогүй болохоос сэргийлэх чадварыг бий болгосноор ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглэгдсэн багц бодлого, хөтөлбөр” гэжээ. Энэ тодорхойлолтын дагуу Азийн хөгжлийн

банкнаас нийгмийн хамгааллын хамралт, түүний нөлөөг үнэлэх зорилгоор Нийгмийн хамгааллын индекс (НХИ)-ийг боловсруулсан.

Нийгмийн хамгааллын индекс (НХИ)-ийг хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн нийгмийн хамгааллын 3 хөтөлбөрийн хамрагалт, хүрээ, ач холбогдлыг үнэлэхэд хэрэглэнэ. Мөн уг индекс нийгмийн хамгааллын гүнзгийрэлт, хүрээг ядуу, ядуу бусаар, жендэрээр ялган харуулдаг.

НХИ нь харьцангуй энгийн үзүүлэлт бөгөөд нийгмийн хамгааллын нийт зардал (E) хөтөлбөрт хамрагдах нийт хүн амын (B) харьцааны үндсэн дээр тооцогддог.

Нийгмийн хамгааллын нийт зардал нь нийгмийн даатгал (social insurance), нийгмийн халамж (social assistance), хөдөлмөр эрхлэлтэд (labor market program) зарцуулсан зардал тус бүрийн нийлбэр юм. Үүнтэй адил хөтөлбөрт хамрагдах хүн ам нь дээрх 3 хөтөлбөр тус бүрт хамрагдах хүн амын нийлбэрээр тодорхойлогдоно.

$$(Esi+Esa+Elmp)/(Bsi+Bsa+Blmp)$$

Үнэлгээ хийхдээ нийгмийн хамгааллын нийт зардал, түүнд хамрагдагчдын харьцааг үндэсний ядуурлын шугамтай харьцуулдаг. Тухайлбал, А улсын НХИ 0.100 гарвал, тухайн улсын нийгмийн хамгааллын зардал (нэг хөтөлбөрт хамрагдагчид ногдох) ядуурлын шугамын 10%-тай тэнцэж байна гэсэн үг. Индексийн утга өндөр гарах тусам тухайн улсын нийгмийн хамгааллын гүйцэтгэл сайн байгааг харуулна.

Улс хоорондын харьцуулалт хийхийн тулд тухайн улсын ядуурлын шугамаар нэг хүнд ногдох ДНБ-ий дөрөвний нэгийг төлөөлүүлж авна. Энэ нөхцөлд НХИ-ийг нэг хүнд ногдох ДНБ-ий хувийн жинтэй шууд харьцуулж болно гэсэн үг. Жишээ нь, тухайн улсын НХИ 0.100 гарч байгаа нь нэг хүнд ногдох ДНБ-ний 2.5%-тай тэнцүү гэсэн үг.

НХИ 0.100 гэсэн утгаар нийгмийн хамгааллын гол хөтөлбөрүүд болох нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн ач холбогдолыг үнэлж тайлбарлъя. Жишээ нь: нийгмийн даатгалын НХИ 0.065, нийгмийн халамжийн

НХИ 0.025 хөдөлмөр эрхлэлтийн НХИ 0.010 гарсан бол ерөнхий НХИ нь эдгээр 3 индексийн нийлбэр $0.065+0.025+0.010=0.100$ юм. 3 дэд индексийн утга ихэнх Азийн улс орнуудад төстэй буюу нийгмийн даатгал илүү давамгайлсан шинжтэй байдаг.

Нийгмийн хамгааллын индекс нь цаашлаад нийгмийн хамгааллын гүнзгийрэлт, хүрээгээр тооцогддог. Гүнзгийрэлт нь нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдагчдад ногдох зарлын хэмжээ, хүрээ нь тухайн хөтөлбөрт хамрагдах боломжтой хүмүүсээс хөтөлбөрт хамрагдсан хүмүүсээр тодорхойлогдоно.

Нийт зардал

Нийт хөтөлбөрт хамрагдагчид

* * *

Нийт хөтөлбөрт хамрагдагчид

*Нийт хөтөлбөрт хамрагдах
боломжтой хүн ам*

Жишээ нь, гүнзгийрэлт 0.200 гэдэг нь нийгмийн хамгааллын зардал ядуурлын шугамын 20%-тай тэнцүү байна гэсэн үг. Үүнтэй адил нийгмийн хамгааллын хамрагалтын индекс 0.500 байна гэвэл хөтөлбөрт хамрагдах боломжтой хүмүүсийн тал хувь нь нийгмийн хамгааллалд хамрагдаж ашиг хүртэж байна гэсэн үг. Нийгмийн хамгааллын гүнзгийрэлт, хүрээний индексийн үржвэр нь ерөнхий НХИ ($0.200*0.500=0.100$) байна.

Эцэст нь, НХИ нь ядуу, ядуу бусад үзүүлж буй нөлөө, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд үзүүлж буй нөлөөгөөр ялгаатай тооцогддог. Тухайлбал, ядуу хүн амын дундах НХИ 0.015, ядуу бус хүн амынх 0.085 бол ерөнхий НХИ $0.015+0.085=0.100$. Энд нийгмийн хамгааллаас ашиг хүртэгчдийн 30 хувь нь ядуу хүн ам байна гэж төсөөлж болно. Үүний үр дүнд ядуу хүн ам нийгмийн хамгааллын үр ашгийн дөнгөж тал хувийг хүртэж байна. Үүнтэй ижилхэн, НХИ эрэгтэй хүн амын хувьд 0.075, эмэгтэй хүн амын хувьд 0.025 бол (эмэгтэйчүүд хүн амын тал хувийг эзэлж буй тохиолдолд тэд мөн адил нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдах боломжтой) эмэгтэйчүүдийн зөвхөн дөрөвний нэг нь нийгмийн хамгааллаас ашиг хүртэж байна

гэсэн үг. Нийгмийн хамгааллын индексийг тухайн улсын засгийн газар нийгмийн хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих, улс орнуудын харьцуулалт

хийхэд өргөн ашигладаг.

Хүснэгт 1-р Монгол улсын 2011-2013 оны нийгмийн хамгааллын зардал, хамрагдагчдын тоог харууллаа.

Хүснэгт 1: Монгол улсын нийгмийн хамгааллын жилийн зардал, хамрагдсан хүний тоо

| Нийгмийн хамгааллын хөтөлбөр | 2011 | 2012 | 2013 |
|---------------------------------|-------------|-------------|-------------|
| Жилийн зардал* (сая) | 1,470,440.0 | 1,846,920.6 | 1,293,777.3 |
| Хамрагдагчдын тоо, total (000s) | 7,345.9 | 8,722.5 | 6,170.6 |
| Үүнээс: Эмэгтэй | 4,025.0 | 4,594.9 | 3,432.0 |
| Эрэгтэй | 3,320.9 | 4,127.6 | 2,738.5 |
| Ядуу | 2,276.2 | 2,557.2 | 1,931.3 |
| Ядуу бус | 5,069.7 | 6,075.6 | 4,239.3 |

Эх үүсвэр: НХХЯ, ҮСХ-ний мэдээг үндэслэсэн судлаачийн өөрийн тооцоо

2012 онд нийгмийн хамгааллын зардал ихээхэн өссөн нь хүн бүрт олгосон “Хүний хөгжлийн сан”-тай холбоотой. Уг мөнгийг 2012 оны 7 сар хүртэл олгосон бөгөөд 2012 оны 9 сард Хүний хөгжлийн сангийн хуулинд өөрчлөлт орж, 0-18 насны хүүхэд бүрт сар бүр 20.000 төгрөг олгохоор болсон. Энэхүү өөрчлөлт нь 2013 онд нийгмийн хамгааллын

зардал, хамрагдагчдын тоо буурахад нөлөө үзүүлсэн.

Хүснэгт 2-р Монгол улсын нийгмийн хамгааллын зардлыг 2009, 2012 оны байдлаар тооцож, үр дүнг харууллаа. 2009 оны байдлаар Монгол улсын нийгмийн хамгааллын зардал ДНБ-ийн 9.9 хувийг эзэлж байсан бол 2012 онд 13.2 хувь болж нэмэгджээ.

Хүснэгт 2: Монгол улсын нийгмийн хамгааллын зардал, төрлөөр

| Нийгмийн хамгааллын төрөл | 2009 оны зардал (сая төгрөг) | 2009 оны хувийн жин | 2012 оны зардал (сая төгрөг) | 2012 оны хувийн жин |
|--|------------------------------|---------------------|------------------------------|---------------------|
| Тэтгэвэрийн даатгал | 332,089 | 51% | 709,383 | 38% |
| Эрүүл мэндийн даатгал | 56,943 | 9% | 114,400 | 6% |
| Ажилгүйдлийн даатгал | 6,112 | 1% | 6,899 | 0% |
| Бусад даатгал | 21,850 | 3% | 69,340 | 4% |
| Нийт нийгмийн даатгал | 416,994 | 64% | 900,022 | 49% |
| Ахмад настны нийгмийн халамж | 37,652 | 6% | 81,985 | 4% |
| Хүүхэд хамгаалал | 26,221 | 4% | 15,825 | 1% |
| Бусад нийгмийн халамж | 149,524 | 23% | 841,893 | 45% |
| Нийт нийгмийн халамж | 213,396 | 33% | 939,703 | 50% |
| Хөдөлмөр эрхлэлт | 21,494 | 3% | 7,196 | 0% |
| Нийт нийгмийн хамгааллын зардал | 651,885 | 100% | 1,846,057 | 100% |
| ДНБ | 6,590,637 | | 13,944,238 | |
| ДНБ-д нийгмийн хамгааллын зардлын эзлэх хувь | 9.9% | | 13.2% | |

Эх үүсвэр: НХХЯ, ҮСХ-ний мэдээг үндэслэсэн судлаачийн өөрийн тооцоо

Хүснэгтээр харахад нийгмийн хамгааллын зардал 2012 онд 2009 оныхоос 2.8 дахин нэмэгджээ. Үүнд нийгмийн халамжийн зардал 4.4 дахин, нийгмийн даатгалын зардал 2.2 дахин нэмэгдсэн. 2009 оны байдлаар нийгмийн

даатгалын зардал 64 хувь, нийгмийн халамжийн зардал 33 хувийг тус тус эзэлж байсан бол 2012 онд бараг тэнцэж 50, 50 хувь болсон байна. Гол өсөлт нийгмийн халамжийн зардалын өсөлт (23 хувиас 45 хувь болж өссөн).

Хүснэгт 3-р Монгол улсын нийгмийн хамгааллын индексийг тооцож харууллаа. 2012 оны байдлаар уг индекс 0.249 буюу Монгол улсын нийгмийн хамгааллын дундаж зардал ядуурлын шугамын 25 орчим хувьтай тэнцүү байна гэсэн үг. Уг индекс 2009 оныхоор 0.206. Эндээс нийгмийн хамгааллын үр ашиг хүртэж болох нэг хүнд ногдох зардлын хэмжээ 2009 оны үетэй харьцуулахад 2012 онд өссөн байна.

Нийгмийн хамгааллын индексийг төрлөөр задлан харвал, нийгмийн халамжийн индекс хамгийн өндөр буюу 0.127, үүний дараа нийгмийн даатгалын индекс 0.122 харин хамгийн бага нь хөдөлмөр эрхлэлтийн индекс

0.001 байна. Энэ нь нийгмийн хамгааллын үр ашиг хүртэж болох нэг хүнд ногдох үр ашгийн хэмжээ тус 3 ангилал бүрт 13%, 12%, 0% байна гэсэн үг. 2009 онтой харьцуулахад нийгмийн халамжийн зардлын үр ашиг 2012 онд хамгийн ихээр өссөн байна.

Хүснэгтээс харахад нийгмийн халамж, нийгмийн даатгалд хамрагдсан “сонгогдох” хүн амаас өндөр байгаа нь хөтөлбөр тус бүрт хамрагдаж буй хүний давхардалтай холбоотой. Жишээ нь: тэтгэврийн даатгалын санд хамрагдсан хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх боломжтой бөгөөд энэ тохиолдолд уг хүнийг 2 дахин даатгалаас ашиг хүртсэн хүнээр тоолсон байна гэсэн үг юм.

Хүснэгт 3: Монгол улсын нийгмийн хамгааллын индекс (НХИ)-ийн тооцоо, төрлөөр 2012

| Үзүүлэлт | Нэгж | Нийгмийн даатгал | Нийгмийн халамж | Хөдөлмөр эрхлэлт | Бүгд |
|--|----------|------------------|-----------------|------------------|-------------|
| Нийт нийгмийн хамгааллын зардал | Millions | 900,021.6 | 939,702.6 | 7,196.4 | 1,846,920.6 |
| Хамрагдагчдын тоо | 000s | 3,965.3 | 4,622.7 | 134.5 | 8,722.5 |
| Сонгогдох хүн ам | 000s | 3,034.0 | 2,867.7 | 130.8 | 6,032.5 |
| Нэг хүнд ногдох ДНБ-ий 25% | 000s | 1228 | 1228 | 1228 | 1228 |
| НХИ | | 0.122 | 0.127 | 0.001 | 0.249 |

Эх үүсвэр: НХХЯ, ҮСХ-ний мэдээг үндэслэсэн судлаачийн өөрийн тооцоо

Хүснэгт 4-р нийгмийн хамгааллын гүнзгийрэлт, хүрээг тооцон харууллаа. Нийгмийн хамгааллын гүнзгийрэлт 0.172 байгаа нь нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдсан нэг хүнд ногдох зардлын хэмжээ ядуурлын шугамын зардлын 17%-тай тэнцэж байгааг харуулж байна.

Нийгмийн хамгааллын индексийн хүрээ 1.466 гарсан нь ихээхэн анхаарал татаж байгаа бөгөөд энэ нь нийгмийн хамгааллын зардал зорилтот хүн амын 146%-ийг хамарсан буюу нийгмийн хамгааллын зардлын нэр төрөл тус бүрт давхар хамрагдалт их байгааг

харуулж байна. Иймд нийгмийн хамгааллын индексийн хүрээг тайлбарлахдаа давхар хамрагдалт ихээхэн байгааг анхаарах хэрэгтэй.

Нийгмийн хамгааллын индексийн гүнзгийрэлт нийгмийн даатгалын хувьд хамгийн өндөр 18.5%, 65.7% буюу нийгмийн даатгалд хамрагдсан нэг хүнд ногдох зардал ядуурлын шугамын 18.5 хувьтай тэнцүү бөгөөд нийгмийн даатгалд хамрагдах боломжит хүн амын 66%-ийг хамруулсан гэсэн үг. Харин нийгмийн халамжийн хүрээ хамгийн өндөр 0.77 хувь байгаа нь зорилтот хүн амын 77 хувийг хамарсныг харуулж байна.

Хүснэгт 4: Нийгмийн хамгааллын индексийн гүнзгийрэлт, хүрээ 2012

| Нийгмийн хамгааллын индекс | Нийгмийн даатгал | Нийгмийн халамж | Хөдөлмөр эрхлэлт | Бүгд |
|----------------------------|------------------|-----------------|------------------|-------|
| Гүнзгийрэлт | 0.185 | 0.166 | 0.044 | 0.172 |
| Хүрээ | 0.657 | 0.766 | 0.022 | 1.446 |
| НХИ | 0.122 | 0.127 | 0.001 | 0.249 |

Эх үүсвэр: НХХЯ, ҮСХ-ний мэдээг үндэслэсэн судлаачийн өөрийн тооцоо

Хүснэгт 5-р НХИ-г хүн амын ядуурлын байдлаар тооцон гаргав. Уг үзүүлэлтийг ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй ядуу хүн амд зарцуулсан нийгмийн хамгааллын зардлын хувийг үндэслэн тооцдог. Ядуу хүн амын хувьд НХИ 0.067 гарсан бол ядуу бус хүн амын хувьд 0.183 байна. Эндээс нийгмийн

хамгааллын зардал ядуугаас илүү ядуу бус хүн амд ихээхэн зарцуулагдсан гэж харагдаж байна. Энэ үзүүлэлт 2009 оны хувьд 0.036 гарсан бөгөөд 2012 оны байдлаар ядуу хүн амд нийгмийн хамгааллын зардлын зарцуулалт бага зэрэг боловч сайжирч байгааг харуулж байна.

Хүснэгт 5: Нийгмийн хамгааллын индекс, ядуурлын байдлаар 2012

| | Ядуу | Ядуу бус | |
|------------------------------------|--------------|--------------|-----------------|
| Нийгмийн хамгааллын зардал | 494838 | 1,352,083 | Нийт НХИ |
| Сонгогдох хүн ам | 6,033 | 6,033 | |
| Нэг хүнд ногдох ДНБ-ний 25% | 1227.6 | 1227.6 | |
| НХИ | 0.067 | 0.183 | |

Эх үүсвэр: НХХЯ, ҮСХ-ний мэдээг үндэслэсэн судлаачийн өөрийн тооцоо

ДҮГНЭЛТ

Монгол улсын нийгмийн хамгаалалд зарцуулах зардал жил бүр нэмэгдэх хандлагатай байна. 2012 оны байдлаар, Монгол улсын нийгмийн хамгааллын зардал ДНБ-ий 13.2-тай тэнцэж байна. Энэ нь Азийн улс орнуудтай харьцуулвал нэлээд өндөр үзүүлэлт. Гэсэн хэдий ч нийгмийн хамгааллын хамрагдалт, хүрээний индекс өндөр бус байгаа нь нийгмийн хамгааллын хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатайг сануулж байгаа хэрэг юм.

Нийгмийн хамгааллын тодорхойлолтын дагуу нийгмийн хамгааллын хөрөнгө оруулалт нь эмзэг байдлыг бууруулах, туйлын ядуу байдлаас ангижрахад чиглэгдсэн байх ёстой. Түүнчлэн байгалийн аюулт үзэгдэл, өвчлөл, эдийн засгийн хямрал зэрэг эрсдлийг даван туулах, өөрсдийн ирээдүйд хөрөнгө оруулалт хийхэд туслах зорилготой. Иймд нийгмийн хамгааллын загвар, үйлчилгээг сайжруулж, зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Азийн хөгжлийн банк, 2001. Нийгмийн хамгааллын стратеги

Азийн хөгжлийн банк, 2009. Нийгмийн хамгааллын индекс тооцох гарын авлага

Азийн хөгжлийн банк, 2013. Нийгмийн хамгааллын индекс, Ази номхон далайн орнуудын үнэлгээний үр дүн

Б. Энхцэцэг, 2011. Монгол улсын нийгмийн хамгааллын индексийн шинэчилсэн тооцоо, тайлан

Монгол улсын засгийн газар, 2012. Нийгмийн халамжийн тухай хууль

Монгол улсын Засгийн газар, НХХЯ, 2012. Хүн ам, нийгмийн хамгааллын үзүүлэлтүүд, Улаанбаатар

ҮСХ, 2012. Ядуурлын дүр төрх судалгаа, Улаанбаатар

ҮСХ, 2010-2012. Статистикийн эмхэтгэл: Нийгмийн халамж, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн жил бүрийн статистик мэдээ, Улаанбаатар